



ГЭМТЭЛ, СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/76

Улаанбаатар хот

Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээний заавар,
эмчилгээний нэр төрөл, зүү эмчилгээнд мөрдөх
журам батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалт, Монголын уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын 2.4.2.8 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 08сарын 08 өдрийн А/378 дугаар тушаал, байгууллагын дотоод журмын 2.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээний журмыг нэгдүгээр, уламжлалтын эмчийн үзлэгийг өвчний түүхэнд бичих дарааллыг хоёрдугаар, уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээний нэр төрлийг гуравдугаар, уламжлалт зүү төөнө өрөөнд мөрдөх журмыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаны дарга (Б.Бат-Оргил), Сэргээн засах эмчилгээний тасгийн эрхлэгч (Г.Ууганбаяр) нарт үүрэг болгосугай.
3. Тушаалыг мөрдөн ажиллахыг Уламжлалт анагаах ухааны их эмч (П.Адил-Оюун)-д үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээ хариуцсан дэд захирал (Р.Гантуяа)-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Э.ГАЛБАДРАХ

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн
Ерөнхий захирлын 2022 оны 05 сарын 09-ны
176 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВД
УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛЭХ ЗААВАР**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Тусламж үйлчилгээний анхан болон лавлагаа шатанд уламжлалт анагаах ухааны оношилгоо, эмчилгээг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлэх, экспортод гаргах гарцыг дэмжих “ бренд ” болгох/-ыг тус тус үндэслэн Гэмтэл Согог Судлалын Үндэсний төвд уламжлалт анагаах ухааны онол, эмнэлзүйн нотолгоонд суурилсан, үйлчлүүлэгч төвтэй тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, тасралтгүй үзүүлэхэд оршино.
- 1.2. Гэмтэл Согог Судлалын Үндэсний төвийн (цаашид ГССҮТ гэх) уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг хэвтэн эмчлүүлэх тасгуудад буюу стационар, амбулаторийн буюу өдрийн эмчилгээний гэсэн хоёр чиглэлээр уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг зохицуулахад оршино.

Хоёр. Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалт

- 2.1. Уламжлалт анагаах ухааны /цаашид УАУ гэх/ эмч нь гэмтлийн өвчний учир ГССҮТ-д хэвтэн эмчлүүлж буй болон амбулаториор өдрийн эмчилгээнд хамрагдаж буй үйлчлүүлэгчдэд уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг өрнийн анагаах ухааны тусламж үйлчилгээтэй хавсран болон дангаар үзүүлнэ.
- 2.2. УАУ-ны эмч нь ГССҮТөвийн мэс заслын болон сэргээн засахын эмчийн зөвлөснөөр эсвэл эмчлүүлэгч өөрөө зөвшөөрсний үндсэн дээр УАУ-ны тусламж үйлчилгээг бусад эмчилгээтэй хавсран эсвэл дангаар үзүүлнэ. Ингэхдээ эмнэлгийн e-Health дотоод цахим программаар уламжлалтын эмчид үзүүлэх хүсэлт илгээсний дагуу эмчлүүлэгчийг үзэж оношлон, шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлнэ
- 2.3. Уламжлалтын их эмч нь үзлэг зөвлөгөө өгөхдөө УАУ-ны батлагдсан стандарт удирдамжийг үндэслэн УАУ-ны оношилгооны аргуудаар үзлэг хийж, оношийг УАУ-ны өвчний ангилал зүйн дагуу тавьж цахим өвчний түүх болон эмчлүүлэгчийн гар картан дээр уламжлалтын эмчийн үзлэгийг бичнэ.
- 2.4. Уламжлалт анагаах ухааны эмч, мэргэжилтэн тусламж, үйлчилгээ үзүүлсэн тухайгаа үйлчлүүлэгчийн өвчний цахим түүх, гар картанд тодорхой бичнэ.

Гурав. Нэр томъёоны тайлбар

- 3.1. “Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ” гэж гадаад, дотоод шалтгаантай, цочмог болон архаг явцтай аливаа өвчин эмгэгийг анагаах буюу хүний бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэндийг сайжруулахад чиглэсэн тусламж, үйлчилгээг;
- 3.2. “Уламжлалт анагаах ухааны оношлогоо” гэж үйлчлүүлэгчийн эрүүл мэндэд үнэлгээ өгөх, өвчний шалтгаан, нөхцөл, хувирал болон эмчилгээний үр дүн, явцыг тодорхойлоход чиглэсэн асуух, үзэх, хүрэлцэх уламжлалт шинжилгээний цогц аргыг.
- 3.3. “Ерөндөг” гэж аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх болон амирлуулах, арилгах, засах чадал, үйлдэл бүхий идээ ундаа, явдал мөр, эм, засал дөрвөн зүйлийг.

- 3.4. "Явдал мөрийн ерөндөг" гэж өвчнөөс урьдчилан сэргийлэх болон аливаа өвчний үе шаттай уялдуулан эмчлэх зорилго бүхий эрүүл мэндийг дэмжих ажил, амьдралын дэглэмийг.
- 3.5. "Амирлуулах эмийн ерөндөг" гэж өвчнөөс урьдчилан сэргийлэх болон аливаа өвчнийг анагаах зорилго бүхий уламжлалт эмийн хэлбэрүүдийг
- 3.6. "Уламжлалт анагаах ухааны засал" гэж аливаа хүч ихтэй өвчнийг анагаах зорилго бүхий уламжлалт эмчилгээний аргуудыг.
- 3.7. "Хануур засал" гэж өвчний цусыг ялгарсан үед тохирох судасны бэлчрээс уламжлалт хангах заалтын дагуу цус гаргах эмчилгээний аргыг;
- 3.8. "Төөнүүр засал" гэж өвчний орныг тодорхойлон, төөнөх бэлчрийн дагуу заалт ёсоор хийх эмчилгээний аргыг хэлнэ.
- 3.9. "Жин засал" хүний биеийн дулаанд нөлөөлж өвчний эвэршээл, хатгалгыг дарах зорилго бүхий халуун, хүйтнээр жигнэх эмчилгээний аргыг;
- 3.10. "Рашаан, дэвтээлгэ засал" гэж эмт бодис найруулан хийсэн буюу байгалын рашаан, шавар, эмт бигнүүр ашиглан өвчнийг гадагш татах, оронд нь амирлуулах зорилго бүхий эмчилгээний аргыг хэлнэ.

Дөрөв. ГССҮТөвийн Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг үзүүлэх эмч, сувилагчийн ажил үүргийн хуваарь

- 4.1. УАУ-ны их эмчийн гардан гүйцэтгэх тусламж үйлчилгээ
- Үзлэг, судас оношилгоо, идээ унд, явдал мөрийн зөвлөгөө,
 - Эмчилгээний явцад болон дараа баримтлах гам дэглэмийн зөвлөгөө
 - Уламжлалт эмийн жор бичилт
 - Цахим өвчний түүхэнд эмчийн үзлэгийг тэмдэглэлийг уламжлалт анагаах ухааны аргаар товч бөгөөд тодорхой бичих, амбулаторийн үйлчлүүлэгчийн гар картан дээр шаардлагатай бол тэмдэглэл хөтлөх.
 - Уламжлалт засал эмчилгээ
 - Хануур
 - Шивүүр
 - Толгойн доргилтын бариа засал
 - Зүү эмчилгээ
- 4.2. УАУ-ны сувилагчийн гардан гүйцэтгэх тусламж, үйлчилгээ
- Эм, тангийн уух ёс, цаг хугацаанд хяналт тавих
 - Уламжлалт бариа засал
 - Төөнүүр
 - Иллэг, бумба засал
 - Дэвтээлэг, жин засал
 - Эмчлүүлэгчийн биед тавьсан зүүг эмчийн зааврын дагуу хугацааг баримтлан тоо ширхгээр нь бүрэн авах.
 - Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн боловсрол олгох

Тав. ГССҮТөвд уламжлалт анагаах ухааны заслын эмчилгээний хэлбэр, хугацаа, давтамж

- 5.1. Хануур засал
- Боолт хийх хугацаа 3 минутаас багагүй, 5 минутаас ихгүй байна.
 - Ханах судасны хэмжээ, байрлал, цусны гарах байдлаас үүдэн ханаснаас хойших хугацаа 1 минутаас 3 минут байна.

- Гар, хөлд ханасан бол цусны урсгалын саарах үед, толгой их биед ханасан бол судсыг хаасан хойно боолтыг авна.
- Хануурыг улиралд харгалзан, ханах зохистой үед жилд нэг удаа буюу өвчний явцаас хамаарац жижиг, ойрын судсыг олон дахин ханах зарчмаар үйлдэнэ.

5.2. Төөнүүр засал

- Бэлчирт харгалзан төөнүүрийг хийхдээ шовгон төөнүүр бол удирдамжид заасан тоогоор, янжууран төөнүүр бол 5-10 минут, монгол төөнө бол 10-15 минут төөнөнө.
- Эмчилгээний төлөвлөгөө, өвчний явцтай уялдуулан 5-10 удаа өнжиж болон дараалан, улиралд нэг буюу жилд таваас цөөн удаа хийнэ.

5.3. Хатгуур засал

- Өвчлөл, бэлчирт уялдуулан, үйлдлийн технологийн зааврын дагуу жилд нэг удаа гүйцэтгэнэ.

5.4. Жин засал

- Бэлчирт харгалзан 10-15 минут хийнэ.
- Эмчилгээний төлөвлөгөө, өвчний явцтай уялдуулан 5-10 удаа дараалан, улиралд нэг буюу жилд таваас цөөн удаа хийнэ.

5.6. Дэвтээлэг, эмт бэгнүүр засал

- Өвчний явц, хувиралд харгалзан ууран дэвтээлэг бол 10-15 минут, усан дэвтээлэг бол 39-40 хэмийн халуунд 10-15 минут, эмт бэгнүүр бол 37-38 хэмийн халуунтай, 10-20 минут хийнэ.
- Эмчилгээний төлөвлөгөө, өвчний явцтай уялдуулан 5-10 удаа дараалан, улиралд нэг буюу жилд таваас цөөн удаа хийнэ.

5.7. Бариа засал

- Өвчлөл, үе шат, өвчин байрлах оронтой харгалзан 10-45 минут хийнэ.
- Бумба тавих дээд хугацаа 20 минут байна.
- Эмчилгээний төлөвлөгөө, өвчний явцтай уялдуулан 5-10 удаа дараалан, улиралд нэг буюу жилд гурваас цөөн удаа хийнэ.

5.8. Шивүүр эмчилгээ

- Бумба тавих хугацаа багадаа 5-10 минут байна.
- Нэгж талбайд, шивүүр хийхдээ шивүүрийн алхаар бол 5-8 удаа, зүүгээр бол 15-20 удаа хатгана.
- Шивүүрийн соруул бумба тавьснаас хойш 10-15 минут болно.
- Эмчилгээний төлөвлөгөө, өвчний явцтай уялдуулан бэлчир сольж 1-2 удаа, улиралд нэг буюу жилд гурваас цөөн удаа хийнэ.

5.9. Зүү эмчилгээ

- Өвчний шинж тэмдэг илэрч байгаа суваг, хэрдсийн тодорхой цэгүүдийг сонгон авч нэг удаадаа 15-20 минут, нийт 7-10 хоног хийнэ.
- Нэг удаад хатгах зүүний тоо өвчний байдлаас шалтгаалан харилцан адилгүй байна.
- Цагаан судлын гэмтлийн үед зүүг цахилгаан зүү, төөнүүртэй хавсран хэрэглэж болно.
- Эмчилгээний төлөвлөгөө, өвчний явцтай уялдуулан 10 хоногийн эмчилгээ хийсний дараах түр завсарлалт 10-14 хоног байна.
- Хөнгөн, дунд зэргийн цагаан судлын гэмтэлтэй үед улиралд 1-2 удаа зүү эмчилгээ хийнэ.

- Хүнд хэлбэрийн цагаан судлын гэмтэлтэй, мөчдийн болон нүүрний мэдээ мэдрэхүй удаан хугацаанд сэргэх өвчний үед эмчилгээ хооронд 10 хоногын түр завсарлалттайгаар нийт 3 удаагийн эмчилгээ хийгдэнэ.

Зургаа. Эмийн эмчилгээний нэр төрөл, өгөх хугацаа

6.1. ГССҮТ-д танг, талх, үрлэн эмийн хэлбэрийг эмчилгээнд хэрэглэнэ. Эмчийн бичсэн 3-4 төрлийн эмийг нэг хоршил эм гэнэ.

6.2. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд өдөрт 3-4 нэр төрлийн эм танг сонгон өглөө, өдөр, орой гэсэн дарааллаар өвчний үе шатанд тохируулан уулгана. Нийт таваас доошгүй хоногийн тусламж, үйлчилгээ үзүүлэхээр зохион байгуулна

6.3. Өдрийн тусламж, үйлчилгээг өдөрт 3-4 нэр төрлийн эм танг сонгон өглөө, өдөр, орой гэсэн дарааллаар уулгана. Нийт долоогоос доошгүй хоногийн тусламж, үйлчилгээ үзүүлэхээр зохион байгуулна

Долоо. Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээний үзүүлэхэд мэргэжилтний оролцоо

7.1 Тасгийн эрхлэгчийн шууд удирдлага дор эмчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангасан хяналт бүхий орчинд УАУ-ны эмч болон сувилагч хийж гүйцэтгэнэ.

7.2 Тасгийн эрхлэгч, УАУ-ны эмч болон сувилагч УАУ-ны Стандарт Үйл Ажиллагааны Зааварчилгаанд (цаашид СҮАЗ гэх) заасан үүргийн дагуу ажиллана

Найм. Уламжлалт анагаах ухааны эмчийн үзлэг

8.1. УАУ-ны эмчийн үзлэгийг амбулатори болон хэвтэн эмчлүүлэх тасагт заавал урьдчилан үзэж үнэлгээ хийн эмчлүүлэгчийн цахим өвчний түүх болон шаардлагатай бол гар картанд эмчийн тэмдэглэл хөтөлж баримтжуулна

8.2. УАУ-ны эмчийн үзлэгийг УАУ-ны болон өрнийн анагаах ухааны үзлэг оношилгооны аргийг ашиглан эмчлүүлэгч бүрт дараах дарааллын дагуу хийсэн байна. /Хавсралт 2-д үзүүлэв /

**ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭХ ТАСАГТ ҮЙЛЧЛҮҮЛЖ БУЙ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ӨВЧНИЙ
ТҮҮХЭНД УЛАМЖЛАЛТЫН ЭМЧИЙН ҮЗЛЭГ БИЧИХ ДАРААЛАЛ**

Дэс дугаар	Эмчийн тэмдэглэлийн дараалал	Оношлох арга	Үзлэгийн хэлбэр	
			Уламжлалт анагаах аргаар	Өрнийн анагаах аргаар /Европ/ ухааны
1	Биеийн ерөнхий байдлыг үнэлж дүгнэх	Харж ажиглах оношилгооны арга		+
2	Зовуурь шаналгааг асууж тогтоох	Асуух оношилгооны арга	+	
3	Эмчлүүлэгчийн төрөлх өвөрчлөлийг тогтоох	Харж ажиглах оношилгооны арга	+	
4	Нүүр царай, дүр төрхийн илрэл, цог сүлдийг оношлох	Харж ажиглах оношилгооны арга	+	
5	Судас барьж оношлох	Хүрэлцэх оношилгооны арга	+	
6	Хэлийг харж оношлох	Харж ажиглах оношилгооны арга	+	
7	Шээсийг харж оношлох	Харж ажиглах оношилгооны арга	+	
8	Таван мэдрэхүйн эрхтнийг оношлох	Харж ажиглах оношилгооны арга	+	
9	Хэсэг газрын үзлэг оношилгоо	Харж ажиглах, хүрэлцэх, чагнах, тогших, тэмтрэх араар оношлох	+	+

Гэмтэл согот судлалын үндэсний төвийн
Ерөнхий захирлын 2022 оны 05 сарын 09-ны
дугаар тушаалын гуравдугаар хавсралт

**УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ
ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭР ТӨРӨЛ**

Нэг. Идээ, явдал мөрийн эмчилгээ /Эмчлүүлэгчдэд өгөх зөвлөгөө, зөвлөмж/

- 1.1. Идээ унд, явдал мөрөө өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор болон, тухайн өвчлөлийн үед улирал, цаг агаарын байдалтай хэрхэн уялдуулан хэрэглэх талаар зөвлөгөө зөвлөмжийг өгөх
- 1.2. Гэмтлийн өвчний үеийн биеийн байдал, зовуурт хоол хүнс, амьдралын хэв маягаа хэрхэн зөв тохируулах аргуудын талаар зөвлөгөө өгөх.

Хоёр. Эмийн эмчилгээ

- 2.1. Амарлиуулах үйлдэлтэй эмүүд
- 2.2. Тан эм
- 2.3. Талхан эм
- 2.4. Үрлэн эм

Гурав. Заслын эмчилгээ /ширүүн/

- 3.1. Хануур засал
- 3.2. Шивүүр
- 3.3. Төөнүүр засал

Зөөлөн засал эмчилгээ

- 3.4. Цахилгаан төөнүүр
- 3.5. Монгол төөнө

Дөрөв. Жин засал

- 4.1. Халуун
- 4.2. Хүйтэн

5. Рашаан дэвтээлгэ засал

- 5.1. Ороох, бэгнэх засал

6. Иллэг, түрхлэг, Татлага, Бумба эмчилгээ

- 6.1. Иллэг засал
- 6.2. Зөгийн балтай татлага
- 6.3. Бумба /галтай/
- 6.4. Бумба /гулгуур/

7. Уламжлалт бариа засал

- 7.1. Толгойн доргилтын бариа засал
- 7.2. Толгой хүзүүний бариа засал
- 7.3. Хэсэгчилсэн бариа засал
 - 7.3.1 Сээр нурууны бариа засал
 - 7.3.2 Ууц нурууны бариа засал
 - 7.3.3 Дээд мөчдийн бариа засал
 - 7.3.4 Доод мөчдийн бариа засал
 - 7.3.5 Гемиплегийн бариа засал
 - 7.3.6 Параплегийн бариа засал



- 7.3.7 Эмчилгээний тостой бүтэн биеийн бариа засал
- 7.3.8 Нүүрний саажилтын үеийн бариа засал
- 7.3.9 Жамц давстай сэргээний бариа засал

- 8. Зүү эмчилгээ**
- 8.1 Хуурай зүү
- 8.2 Цахилгаан зүү
- 8.3 Төөнүүртэй зүү

ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН УЛАМЖЛАЛТ ЗҮҮ ТӨӨНӨ ЭМЧИЛГЭЭНД МӨРДӨХ ЖУРАМ

Энэхүү журам нь Гэмтэл согог судлалын үндэсний төвийн сэргээн засах тасгийн уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ болох зүү, төөнүүр эмчилгээний өрөөнд хийгдэж буй тусламж үйлчилгээг чанар хүртээмжтэй үзүүлдэгтэй холбоотой харилцааг зохицуулна.

- 1. Хэвтэн эмчлүүлэх тасгаас ирж үйлчлүүлж буй эмчлүүлэгч нартай холбоотой мөрдөх журам**
 - Эмчлүүлэгч нь тухайн хэвтэн эмчлүүлж буй тасгийн эмчлэгч эмчийн зөвшөөрлөөр зүү, төөнө эмчилгээ үйлчилгээг авна.
 - Хэрэв өөрийн хүсэлтээр уламжлалт эмчилгээ хийлгэх бол заавал эмчлэгч эмчдээ эхлэн мэдэгдэн, эмнэлгийн e-Health цахим программаар нэр нь ирсний дагуу уламжлалтын эмч үзлэг хийж эмчилгээнд хамруулна.
 - Хэвтэн эмчлүүлэгчид уламжлалт, зүү төөнө эмчилгээнд эмчийн заасан цагийн хуваарийн дагуу ирж үйлчлүүлнэ.
 - Өөрөө алхаж чадахгүй, асаргаатай байгаа, сэхээн амьдруулах тасгийн өвчтөнүүдэд эмч хэвтэн эмчлүүлэх өрөөнд нь очиж эмчилгээ үйлчилгээг үзүүлнэ.
 - Үйлчлүүлэгч зүү эмчилгээнд ирэхийн өмнө өлөн байж болохгүй, халуун ус, цай, хоол идсэн байх хэрэгтэй.

- 2. Амбулатори болон өдрийн эмчилгээнд ирж буй үйлчлүүлэгч нартай холбоотой мөрдөх журам**
 - Амбулаторийн үзлэгийн цаг авч үйлчлүүлнэ.
 - Эмчлүүлэгч өөрийн хувийн өвчний карт болон иргэний үнэмлэхээ авч ирнэ.
 - Амбулаториор эмчилгээнд хамрагдах хүмүүс 08:30-12:00 цагийн хооронд үйлчлүүлнэ. Шинээр ирж буй эмчлүүлэгчид эхний өдөр 13:00 -16:30 цагийн хооронд үйлчлүүлж болно.
 - Гадуур хувцсаа өлгүүрт өлгүүлэн, маск зүүж, улавч заавал өмсөнө.

- 3. Зүү, төөнө эмчилгээний өрөөнд эмчилгээнд хамрагдаж буй үйлчлүүлэгчдийн мөрдөх журам**
 - Эмчилгээнд ирэхдээ өглөөний цайгаа заавал уусан байх.
 - Артерийн даралт ихэсдэг хүмүүс даралтаа тогтмол хянах.
 - Эмчилгээний өрөөнд орох болон гарахдаа спиртэн суурьтай гар ариутгагчаар гараа халдваргүйжүүлэх.
 - Эмчилгээний өрөөнд хог хаягдал ил задгай хаяхгүй байх.
 - Биеийн зүү эмчилгээ хийлгэж байгаа бол хувийн хэрэглэлээ бэлдэж авч ирнэ /эмчилгээний даавуу, сальфетик гэх мэт/
 - Биед чөлөөтэй дулаахан хувцаслах, хэт бариу хувцас өмсөхгүй байх
 - Хувийн ариун цэврийг сахина.
 - Эмчийн хэлж зөвлөсөн гам дэглэмийн мөрдөнө
 - Зүү эмчилгээний явцад биед таагүй шинж тэмдэг илэрсэн даруйд зүү эмчдээ мэдэгдэж байх.
 - Зүү тавьсан үед хөл гараа хөдөлгөх, зүүг өөрөө дур мэдэн авч болохгүй.
 - Эмчилгээ үйлчилгээнд дарааллын дагуу соёлтой үйлчлүүлнэ



- Эмч, үйлчлүүлэгч нь эмчилгээний турш харилцан бие биедээ соёлтой харьцаж өөртөө болон бусдад таатай орчинг бүрдүүлнэ.

Жич: Зүү эмчилгээний үр дүн эмчээс болон үйлчлүүлэгч /өөрөө/-ээс ихээхэн хамааралтай учир нэг удаагийн эмчилгээний /15-20 минут/-ын турш гар утасаар ярих, чанга дуу чимээтэй зүйл үзэж сонсохгүй байх. зүү эмчилгээ хийлгэж байгаа бусад үйлчлүүлэгчийн сэтгэл санааг хямраах зүйл ярих зэрэг нь биеийн хийг арвидуулж өвдөлт зовуурийг улам нэмэгдүүлэх эрсдэлтэй тул эмч эмчилгээний өмнө анхааруулж тайлбарлаж өгнө.